



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 12, өдөр

Дугаар А/160

Мөрөн сум

Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх  
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.15, 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.2, 35.1.4, 37 дугаар зүйлийн 37.2, 42 дугаар зүйлийн 42.2, Засгийн газрын 2021 оны 343 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэд оршин суугчдын эзэмшил, өмчлөлд шилжих нийтийн орон сууцны барилгад тавих орон нутгийн хяналтыг сайжруулан, барилга угсралтын үе шат, явцын хяналтыг гүйцэтгүүлж байхыг "Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ-т хариуцуулсугай.

2. Иргэд оршин суугчдын эзэмшил, өмчлөлд шилжих нийтийн орон сууцны барилгын гүйцэтгэгч бүртэй хяналтын гэрээг байгуулж, захиалагчийн хяналтыг Барилгын тухай хууль, Барилга захиалагчийн дүрэм бусад норм стандартыг мөрдөн үе шатны ажил бүрт акт протоколоор баталгаажуулж ажиллахыг "Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ-н захирал (Д.Батчулуун)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Ш.ИДЭРБАЯСГАЛАН